



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2023 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 15-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

ТҮР ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2023 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр, Лхагва гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2-3
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	4-8
<i>Горимын санал</i>	4-8

Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы Хянан шалгах түр хороо /Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой зарим компаниудын нүүрс олборлолт, борлуулалт, тээвэрлэлт, экспортын үйл ажиллагаа болон бусад бараа, ажил, үйлчилгээ худалдан авалтын үйл ажиллагаанд хяналт хийх, нотлох баримтыг шинжлэн судлах нээлттэй сонсгол зохион байгуулах, иргэд, олон нийтийг мэдээллээр хангах, хяналт шалгалтын тайланг Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы хугацаанд багтаан танилцуулах үүрэг бүхий/-ны 11 дүгээр сарын 15-ны өдөр /Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл

Хянан шалгах түр хорооны дарга Б.Энхбаяр ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 10 гишүүнээс 6 гишүүн хүрэлцэн ирж, 60.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 13 цаг 43 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

*Томилолттой: Б.Жаргалмаа, С.Ганбаатар;
Эмнэлгийн чөлөөтэй: М.Оюунчимэг, Ж.Сүхбаатар.*

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт шалгалт, үнэлгээний газрын Хяналт шалгалтын хэлтсийн зөвлөх Ж.Монголжингоо, мөн газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн референт М.Мандхай нар байлцав.

Хэлэлцэх асуудлын дараалалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат, О.Цогтгэрэл нарын тавьсан асуултад Түр хорооны дарга Б.Энхбаяр хариулж, тайлбар хийв.

Түр хорооны дарга Б.Энхбаяр Түр хорооны хянан шалгагч, шинжээч томилох асуудлуудыг хэлэлцэх учир хуралдааныг хаалттай горимд шилжүүлбэ гэсэн горимын санал гаргав.

Б.Энхбаяр: Горимын саналыг дэмжбэ гэсэн санал хураалт явуулбэ.

Зөвшөөрсөн: 4

Татгалзсан: 2

Бүгд: 6

66.7 хувийн саналаар горимын санал дэмжигдсэн тул хуралдааныг 15 цаг 00 минутад хаалттай горимд шилжүүлэв.

15 цаг 07 минутад хуралдааныг нээлттэй горимд шилжүүлэв.

Нээлттэй хуралдаан 20 минут үргэлжилж, 10 гишүүнээс 6 гишүүн хүрэлцэн ирж, 60.0 хувийн ирцтэйгээр 15 цаг 10 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ХЯНАН ШАЛГАХ ТҮР ХОРООНЫ
ДАРГА

Б.ЭНХБАЯР

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

Ганбат гишүүн надаас саллаа. Ганбат гишүүн саналаа хэлье.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр,
Мягмар гараг Төрийн ордон “засаг”
танхим 12 цаг 43 минут.

ТҮР ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Б.Энхбаяр: Төрийн болон орон нутгийн өмчит өмчийн оролцоотой зарим компаниудын нүүрс олборлолт, борлуулалт, тээвэрлэлт, экспортын үйл ажиллагаа болон бусад бараа, ажил үйлчилгээ, худалдан авалтын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх нотлох баримтыг шинэжлэн судлах нээлттэй сонсгол зохион байгуулах иргэд олон нийтийг мэдээллээр хангах хяналт шалгалтын тайланг Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы хугацаанд багтаан танилцуулах үүрэг бүхий Хянан шалгах түр хорооны 2023 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн хуралдаан гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул нээснийг мэдэгдье ээ.

Өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

1.Хянан шалгах түр хорооны хянан шалгагчийг чөлөөлөх тухай тогтоолын төсөл,

2.Хянан шалгах түр хорооны шинжээчийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай тогтоолын төсөл гэсэн 2 асуудал хэлэлцэнэ.

Чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасны дагуу хянан шалгагч, шинжээчийг томилох, чөлөөлөх асуудлыг хаалттай горимоор хэлэлцэх асуудлаар уу?

Уучлаарай хэлэлцэх асуудлын талаар өөр саналтай гишүүн байна уу?

Д.Ганбат: Ингээд та бүхнийхээ өдрийн мэндийг мэдье ээ.

Ингээд Нүүрсний түр хороо маань бас ингээд идэвхтэй ойр ойрхон хуралдаад байгаа. Бид бүхэн ингээд 7 сард байгуулагдсан Нүүрсний түр хороо 2 дахь удаагаа байгуулагдаж байгаа. Хороо өдий ингээд тооцоод үзэхээр бид нар 5 сар өнгөрчээ. Бид нарын ярьдаг юм сүүлийн үед ажлын төлөвлөгөөгөө гаргачихсан байдаг. Энэ шинжээч гэдэг энэ хүмүүсээ байнга томилоод л ингээд л аваад л ингээд явж байна. Тэгээд цаг хугацаа маань ингээд яваад байна аа. Тэгэхээр бид нар ямар ч байсан нөгөө нотлох баримтыг шинэчлэн тогтоох энэ асуудлууд байгаа. Бид нарыг цаг хугацаа хүлээхгүй байна. Тэгэхээр ямар ч байсан нүүрсний түр хороо маань ойрын үед ер нь юу яая. Надад санал байна. Ямар санал байна вэ гэхээр энэ Эрдэнэс, Тавантолгойд хамгийн сүүлийн үед ажиллаж байгаа, ажиллаж байсан нэлээн олон жил ажилласан бараг байгуулагдахаас нь эхлээд ажилласан Ганхуяг гэдэг хүн байна.

Өнөөдөр Эрдэнэс Тавантолгойн захирлаар ажиллаж байгаад цагдан хорих ангид байж байна. Тэгэхээр энэ хүнээ шүүхээр гэм буруутай нь одоохондоо тогтоогдоогүй байна. Тэгээд үндэслэлтэй болоод мэдээжийн хэрэг цагдан хорих арга хэмжээ авсан байх аа. Энэ хүнийг маш яаралтай дуудаж, байгаа нөхцөл байдлын талаар тодруулж асууя гэсэн ийм саналыг гаргаж байна аа.

Тэгэхээр өнөөдрийн энэ хэлэлцэх асуудалдаа оруулаад тэгээд энэ хурлаа тэгээд үргэлжлүүлнэ гэж бодоод маргааш ч юм уу үргэлжлүүлээд энэ нөхрийг ингээд дуудаад асуучихад бол иргэд ч хүлээж байна. Бид нар ч гэсэн нэг ажил амжуулаад авчих юм гэсэн ийм бодолтой байна. Ер нь заавал хүний үгийг

сонсох ёстой. Тэндээс ямар зүйл гарч ирэх юм яах юм ийх юм тэ. Одоогоор шүүх дээр очоогүй ямар нэгэн байдлаар ял төлөвлөөгүй ийм байна. Тэгэхээр дуудаад асуух бүрэн боломжтой. Энэ үед нь бид нар яаралтай амжуулъя гэсэн ийм саналыг гаргаж байна. Энэ саналыг дэмжиж өгөөч гэж гишүүдээс хүсэж байна.

Бид нар бас ганцхан шинжээч тойроод л ингээд яваад байж болохгүй шүү дээ. Ямар нэгэн ажлыг амжуулах ёстой. Тэгээд хэд хэдэн хүмүүс дээр хориг тавих шаардлагатай юм уу гэж бодож байна. Энийг нүүрсний дэд хороогоороо бид нар хэлэлцээд ишийдвэрийг нь гаргачих хэрэгтэй байна. Тухайн үед ажиллаж байсан Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга нарыг энэ сайдуудыг бас хилийн хориг тавьсан нь зөв байх аа. Өөр цаашаа бид хууль шүүхийн өмнө энэ түр хорооны өмнө бүгд тэгш ийм байх ёстой. Ард иргэд бид нар мэдээллийг нь авч өгөх ёстой. Энэ дээр нэмээд Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд ажиллаж байсан энэ хүмүүсийг бас хилийн хориг тавья. Тийм албан бичгийг энэ нүүрсний өнөөдрийн дэд хорооны хурлаас гаргах ёстой.

Энэ Үндэсний Аудитын газрын ингээд дүгнэлт гарчихсан байна аа. Ингээд гишүүд түрүүчээсээ ингээд тавиад эхэлчихсэн байна. Энэ бол нээлттэй ийм зүйл байна. Өнөөдрийн бид нарын ингээд энэ асуудалд яаж хандаж байгаа, яаж санал өгч байгаа гэдгээр манай нүүрсний дэд хорооны гишүүдийг хэр зэрэг асуудалд зөв зүйтэй байр суурь эзэлж оролцож байгаа гэдэг нь олон нийтэд харагдана. Энэ дээр төмөр зам, оффтейк гэрээ, түрүүчээсээ манай эрх бүхий байгууллага аудитын газар ингээд дүгнэлтээ гаргачихжээ. Энэ байгууллагууд маань ажлаа хийгээд байдаг. Бид бүхэн 5 сар болчихоод байхад яг ингээд дорвитой ямар нэгэн ажил хийгээгүй байна. Шинжээч тойроод яваад байна. Шинжээчдийн дүгнэлтийг хүлээлгүйгээр хийж болох ийм асуудлууд

байгаа юм байна. Энэ зүйлийг ингээд хийчихвэл хийх нь зүйтэй гэсэн саналыг гаргаж байна.

Манай Хууль зүйн сайд Улсын Их Хурлын гишүүн 2 хүн маань дараалаад ингээд манай дүрсний дэд хороог ахалж байгаа нь манай төр засгаас хэр их анхаарал тавьж байгаагийн илэрхийлэл гэж бодож байна олонх бол. Энэ нь ч зөв зүйтэй асуудал гэж үзэж байна. Тэгээд энэ 2 маань өмнө нь.

Б.Энхбаяр: Ганбат гишүүн хэлэлцэх асуудал дээр нэг асуудал нэмэх Ганхуягийг гэрчээр одоо аваад ирье гэдэг нэг горимын санал,

2.Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 3 гишүүнд гишүүнд хилийн хориг тавья гэдэг 2 дахь горимын санал.

Өөр 3 дахь нь та юу гаргачхав.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын сайд байсан хүмүүсийг бүгдийг нь хилийн хориг тавья гэдэг ийм 3 санал гаргаж байгаа юм байна гэж ингээж ойлголоо.

Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль болон Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд энэ асуудал хууль үргэлжилсэн. Бид хуулийн хүрээнд ажиллаж байгаа. Улсын Их Хурлын дэгийн тухай хуулийн 9.5-д Тухайн 7 хоногт нэгдсэн, Байнгын дэд, Түр хороо, ажлын хэсгийн хуралдаанаар хэлэлцэх асуудлын тов дарааллыг Зөвлөлийн саналыг харгалзан Улсын Их Хурлын дарга батална гэсэн.

Энэ 7 хоногийн хуралдах асуудалд Түр хорооны хянан шалгагч, шинжээчийг томилох, чөлөөлөх асуудлыг хэлэлцэхээр хурлын тов зарлагдсан байгаа, нэг.

Хоёрт таны ярьж байгаа энэ асуудал Улсын Их Хурлын түр хороонд байтугай Улсын Их Хуралд байхгүй л эрх

яриад байна даа. Бид нар 76-уулаа 100 хувь санал нэгдээд ч бас оролцож болдоггүй харилцаа байгаа шүү дээ. Гаргаж болдоггүй бас хил хязгаар шийдвэр байгаа. Тухайлбал таны хөндөж байгаа эрх хязгаарлах таслан сэргийлэх арга хэмжээ бол зөвхөн Монгол Улсын шүүхээс авдаг арга хэмжээ байгаа хуультай.

Хэрвээ одоо ийм шийдвэр Улсын Их Хурал тэр хууль хамаагүй ээ гээд гаргах юм Үндсэн хууль зөрчсөн асуудал руу орно. Тэгэхээр та Үндсэн хууль зөрчсөн санал гаргаж байна гэсэн үг. Тийм хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, шүүн таслах үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцох нөлөөлөх, шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлэх буюу шүүхийн Үндсэн хуульчлагдсан бүрэн эрхийн асуудлыг та яриад байна. Одоо хэдүүлээ цуг сууж байгаад шийдчихье ээ гээд яриад байна л даа. Тэгэхдээ энэ гэрчээр оролцох нэрсийн асуудал бол би өмнөх Түр хорооны хуралдаанаар хэлсэн. 11 дүгээр сарын 27-ны өдөр буюу 12 хоногийн дараа түр хорооны хуралдаанаар сонсголын товыг зарлаж хэлэлцэх асуудалд гэрчээр оролцох албан тушаалтнуудын нэрсийн жагсаалтыг Түр хороо батална. 7 хоногийн өмнө батлах хуультай байгаа юм.

Тийм учраас энэ хурал дээр та гэрчээр оролцох дуудах энэ зүйл албан тушаалтнуудыг хэлэлцэх үеэр та энэ асуудлыг саналаа гаргах бололцоотой гэдгийг 1 дүгээрт хэлмээр байна.

Хоёрдугаарт одоо шинжээчийн дүгнэлт гараагүй байхад Улсын Их Хурлын гишүүд сураг ажгаар юм уу, сэжиг таамгаар үнэлэлт, дүгнэлт өгөх, буу халах үйл ажиллагаа явуулах нь хяналт шалгалтын хуулиар боломжгүй байх гэдгийг бас танд хэлье ээ.

Ингээд хэлэлцэх асуудалдаа орё.

Цогтгэрэл гишүүн хэлэлцэх асуудал дээр санал хэлье. Цогтгэрэл гишүүн.

О.Цогтгэрэл: Өнөөдрийн түр хорооны хурлаар хэлэлцэх асуудал нь хянан шалгагчийг татах, солих, шинжээчийг нэмэх, хасах ийм асуудал байна л даа. Яг одоо үндсэндээ энэ шинжээч томилох эс томилох гэдэг асуудал энэ Түр хорооны сүүлийн хэдэн ч хурлын асуудал болчхов. Гэтэл нөгөө Түр хорооны сонсголын хурал чинь 12 сарын 4 гээд бараг бараг 2 долоо хоногийн дараа гээд урьдчилсан тов ийм товтой ажил яваад байдаг, нэгдүгээрт нь.

Тэгэхээр яг одоо чанартай шинжээч хянан шалгагч нь ажиллаад ажиллах нөхцөл бололцоо цаг хугацаа тэгээд энэ сонсгол чанартай явах ийм бололцоо боломж ер нь байна уу үгүй юу. Одоо ингэж байгаад амжихааргүй болчихлоо гэдэг үндэслэлээр энэ сонсгол чинь энэ он дотроо багтах багтахгүй асуудал яригдах их өндөр магадлалтай болчихлоо гэж бодож байна. Магадгүй энэний чинь цаана ингээд харахаар нэг л их хэдэн шинжээчийг хольсон сольсон. Өчигдөр тавьчаад өнөөдөрт буцаан татлаа л гэх юм. Энэний чинь цаана энэ сонсгол чинь цаг хугацаандаа явагдахгүй байх тийм бодит сонирхол байгаа юм биш биз дээ? 1 дүгээрт нь.

Хоёрдугаарт нь шинжээч томилохоор баахан Сангийн яамнаас хүмүүс ороод ирэх юм. Гэтэл Сангийн яам гэдэг чинь Сангийн яамны өнөөдрийн энэ шинжээчдийг санал болгож байгаа Төрийн нарийн бичгийн дарга Ганбат гэдэг хүн чинь энэ нүүрсний будилаан гарч байхад ТУЗ-ийн дарга, тэрнээс хойших энэ үед бүрэн эрхт төлөөлөгч БЭТ өнөөдөр Төрийн нарийн бичгийн дарга. Тэгээд шинжээч хянан шалгагчдыг санал болгодог.

Тэгэхээр энэ бүгдийн чинь цаана зарим асуудлуудыг улс төрийн зорилгоор

ашиглах заримыг нь хаацайлах энэ нөхцөл бололцоо чинь олон зүйл чинь яг энэний цаана бүрдэх гээд байна шүү дээ.

Тийм болохоор энэ шинжээч хянан шалгагч томилно оо гэдэг асуудлыг илүү нээлттэйгээр, магадгүй сонгон шалгаруулалттайгаар, илүү нээлттэй тийм хардлага сэрдлэггүйгээр явуулах боломж бололцоог бид нар хайх ёстой биш үү? Ингээд ерөөсөө л Түр хорооны хурал болдог хэдэн хянан шалгагч шинжээч тавина гэдэг энийгээ хаалттай хийдэг. Хэдэн сангийн яам төрөөр эргэсэн хэдэн хүн тавьдаг. Яг үнэндээ төр гэж байгаа мөртөө энэ чинь өнөөдрийн энэ сонсгол зохион байгуулах эрх бүхий сонсгол зохион байгуулах гэж байгаа бүрэлдэхүүнд энэ ашиг сонирхол орох юм биш биз дээ гэдэг үндсэндээ хардлага биш би бүр бодитоороо л үнэнийг хэлж байна.

Тийм учраас энэ хараат бусаар ажиллах боломж бололцоотой шинжээч хянан шалгагчийг нээлттэйгээр ийшээ оруулж ирдэг ийм боломж бололцоог бүрдүүлье л дээ хамгийн гол нь. Энэний чинь цаана дахиад л яг хардлага сэрдлэг үлдэх гээд байна. Түүрүүн миний хэлдэг. Өнөөдрийн энэ шинжээчдийг санал болгоод байгаа, аваад байгаа бүрэлдэхүүн чинь энэ төр засагтай холбоотой. Дахиад дээрээс нь өнөөдрийн тэр бүрэн эрхт төлөөлөгч, гүйцэтгэх захирал, ТУЗ-ийн дарга ТНБД гэх мэтээр энэ чинь ингээд ашиг сонирхол бүхий дахиад л энэ хардлага сэрдлэг салахааргүй л ийм л нөхцөл байдалд шинжээч хянан шалгагч дээр үүсээд л ингээд яваад байна л даа.

Тэгэхээр энэн дээр энэ илүү нээлттэйгээр хараат бус хянан шалгагчийг ажиллуулах шинжээч ажиллуулах боломж бололцоог нь Түр хороон дээр олгох талаас нь анхааръя аа. Энэн дээр ямар боломж бололцоо байна. Энийг нээлттэй зарлаж байгаад авбал жишээ нь яадаг юм.

Б.Энхбаяр: Өнөөдрийн хэлэлцэх асуудалд 2 хянан шалгагчийг чөлөөлж, нэг шинжээчийг томилох асуудлыг бид хэлэлцэх асуудалд санал болгож байгаа.

Нэг шинжээч нь бол Улсын Их Хурлаас байгуулагдсан Эмийн хяналтын түр хороонд хянан шалгагчаар томилогдсон байсан бөгөөд Түр хороон дарга Чинбүрэн гишүүн маань гол ачааллыг үүрч байгаа хянан шалгагч учраас Эмийн хяналтын түр хорооноос гарах боломжгүй байна гэсэн. Тэгэхээр 2 хянан шалгагч Улсын Их Хурлын хянан шалгалтын ажилд нэг хүн дунд нь ингээж ажиллах боломжгүй байна гэдгээр нэг хүнийг, томилсон хүнийг чөлөөлөх асуудал орж ирж байна.

Нөгөө хүн нь бол өмнөх 9 сард хянан шалгагчаар томилогдсон байсан 5 хүний нэг байгаа. Гаалийн байгууллагаас томилогдсон хүн. Тийм тэгээд би бол энэ Түр хороонд ажиллах боломжгүй гэж үзэж байгаа. Түр хороон даргын хувьд, тийм. Яагаад гэхээр ер нь бол насаараа гаальд ажилласан тэр дотроо Улсын Их Хурлын энэ Түр хорооны хяналт шалгалтын асуудалд гаалийн байгууллагын асуудал нэлээн өргөн цар хүрээтэй шалгагдана. Тэгэхээр энэ хүн өөрөө тэнд ажиллаж байсан хүн энэ шалгалтыг өөрөө хариуцаж хийх боломжгүй буюу сонирхлын зөрчилтэй гэж үзэж байгаа юм.

Тийм учраас чөлөөлөх саналыг оруулж ирж байгаа юм гэдгийг хэлье.

Энэ яг хянан шалгагчийн асуудал чинь хаалттай горимоор ярья.

Тэгэхээр би бас хаалттай юун дээр хэлье, тэгэх үү?

Хэлэлцэх асуудалдаа орёе оо. Горимын саналаар санал хураая.

Баталчихлаа, ингээд баталсан.

Хэлэлцэх асуудал дээр хянан шалгах түр хорооны хянан шалгагчийг чөлөөлөх асуудлыг хэлэлцье.

13.00 цагт

Энэ асуудлыг Улсын Их Хурлын дэгийн тухай хуульд заасанчлан 12 дугаар зүйлийн 12.2, 12.3 дахь хэсэгт заасныг үндэслэн хаалттай горимоор хэлэлцье ээ гэдгээр гэдэг горимын саналаар санал хураалт явуулъя.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ
П.МЯДАГМАА*

Санал хураалт.

66.7 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Хуралдааныг хаалттай горимд шилжүүлэе.

Нээлттэй болчихсон уу? Хүн намын удирдах зөвлөлийн гишүүдээ хамгаалахгүй шүү. Нүүрсний хулгайд оролцсон Доржханд тийм улс төржсөн асуудал байхгүй шүү би хэлчихье.

Харин нүүрсчдийн мафийн гар хөл болохгүй шүү.

Хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдааныг нээлттэй горимд шилжүүллээ.

Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой зарим компаниудын нүүрс олборлолт, борлуулалт, тээвэрлэлт, экспортын үйл ажиллагаа болон бусад бараа, ажил үйлчилгээ, худалдан авалтын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх нотлох баримтыг шинжлэн судлах нээлттэй сонсгол зохион байгуулах иргэд олон нийтийг мэдээллээр хангах, хяналт шалгалтын тайланг Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы хугацаанд багтаан танилцуулах үүрэг бүхий Хянан шалгах түр хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул энэ өдрийн хуралдаан өндөрлөснийг мэдэгдье. Баярлалаа гишүүдэд.